



АДААЦАГ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.МОНХЦЭЦЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgov@audit.gov.mn

2017.02.08 № 01/09 ДУА-2017/14/СТА - ТЧЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчин 100,000.00 төгрөгийн үнэтэй тэргэнцэр худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулж, хөрөнгөнд бүртгэлгүй зардалд тайлгагасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ Сангийн сайдын 55 тушаалын 6 дугаар хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны A/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

- Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх, цаашид холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах;

000000018

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Адаатаг сумын Цэцэрлэгийн эрхлэгч Б.Мөнхцэцэг, нягтлан бодогч Θ.Уранбилэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

ШИНЖЭЭЧ




Ж.УГТАХБАЯР

ЗКЛ0006 9003475


ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ



Б.МОНХЦЭЦЭГ

НЯГТЛАН БОДОГЧ



Θ.УРАНБИЛЭГ

¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/